



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 580

Улаанбаатар хот

“Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2023 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (А.Баясгалан)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн  
580 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ЭРДЭНЭСАНТ АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 оны Гүйцэтгэл	2022 он		2023 оны Төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	ХБГ		2023 Төл/ 2022 Төл	2023 Төл- 2022 Төл
	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>							
1	Улсын чанартай зам засварын ажил	мян.төг	942,896.20	1,834,454.50	979,522.30	1,980,000.00	1.08	145,545.50
	Орон нутгийн чанартай зам засварын ажил	мян.төг	8,181.80	181,818.20	69,000.00	90,909.10	0.50	(90,909.10)
2	<b>Нийт орлого</b>	мян.төг	<b>951,078.00</b>	<b>2,016,272.70</b>	<b>1,048,522.30</b>	<b>2,070,909.10</b>	1.03	54,636.40
3	<b>Нийт зардал</b>	мян.төг	<b>1,213,819.60</b>	<b>2,005,372.90</b>	<b>1,211,393.50</b>	<b>2,066,693.10</b>	1.03	61,320.20
3.1	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	239,761.10	387,080.40	324,066.20	275,577.50	0.71	(111,502.90)
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	мян.төг	<b>(262,741.60)</b>	<b>10,899.80</b>	<b>(162,871.20)</b>	<b>4,216.00</b>	0.39	(6,683.80)
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	мян.төг	<b>(262,741.60)</b>	<b>9,809.80</b>	<b>(162,871.20)</b>	<b>3,794.40</b>	0.39	(6,015.40)
6	Төсвийн төлбөр	мян.төг	223,695.30	340,606.00	185,690.50	281,226.30	0.83	(59,379.70)
6.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	мян.төг	11,823.60	1,090.00	-	421.60	0.39	(668.40)
6.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	мян.төг	96,243.70	140,489.00	76,346.50	146,363.60	1.04	5,874.60
6.3	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,067.80	1,200.00	1,029.70	1,050.00	0.88	(150.00)
6.4	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	58,161.70	152,301.50	74,695.60	86,399.30	0.57	(65,902.20)
6.5	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	2,012.60	2,918.00	2,918.00	2,918.00	1.00	-
6.6	ХХОАТ	мян.төг	46,036.70	42,057.50	29,813.90	43,173.80	1.03	1,116.30
6.7	Бусад	мян.төг	8,349.20	550.00	886.80	900.00	1.64	350.00
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	2,192.70	-	758.90	0.35	(1,433.80)
8	Ажиллагсдын тоо	хүн	39.00	41.00	41.00	41.00	1.00	-
9	Нийт цалингийн сан	мян.төг	522,884.30	516,076.40	515,142.30	595,857.20	1.15	79,780.80
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	1,117.30	1,048.90	1,047.00	1,211.10	1.15	162.20
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.28	0.99	1.16	1.00	1.01	0.01
12	Хөрөнгө оруулалт	мян.төг		48,000.00	-	80,000.00	1.67	32,000.00
13	Нийт авлага	мян.төг	38,517.00	19,085.90	25,085.90	19,085.90	1.00	-
14	Нийт өглөг	мян.төг	333,159.10	125,000.00	546,650.70	150,000.00	1.20	25,000.00
14.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	333,159.10	125,000.00	546,650.70	150,000.00	1.20	25,000.00
14.2	Урт хугацаат өр төлбөрт	мян.төг	-	-	-	-	-	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 12 дугаар сарын 19 -ны өдрийн  
580 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**"ЭРДЭНЭСАНТ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж бүрийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
1	Өөрөө буулгагч автомашин	ш	1	80,000.00	80,000.00
НИЙТ ДҮН					80,000.00

/Наян сая төгрөг/